

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

1. Үндсэн үйл ажиллагаа

Газрын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байна. “Байгаль орчны газар”, “Энхжих мандарваа” ӨЭМТөв, “Нийтлэг үйлчилгээний алба”, “Орхон аймгийн Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөр”, “17 дугаар сургууль”, “Унага цэцэрлэг” зэрэг байгууллагуудын 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэж байна.

“28 дугаар цэцэрлэг”-ийн 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг дуусгаж тус байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт зөрчил, дүгнэлтийг танилцуулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 84 байгууллагын 2025 оны III улирлын **“Шилэн дансны тухай хууль”**-ийн хэрэгжилтэд дотоод аудитыг гүйцэтгэлээ. Шилэн дансны хуулийн хэрэгжилт 98.4%-тай дүгнэгдсэн. Дотоод аудитын тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2025.10.03-ны өдрийн 53/25 дугаартай удирдамжаар Жаргалант сумын ЗДТГ-ын 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг гүйцэтгэж, байгууллагын дарга, нягтлан бодогч, холбогдох албан тушаалтнуудад зөрчил, дүгнэлтийг танилцуулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2025.10.03-ны өдрийн 54/25 дугаартай удирдамжаар Жаргалант сумын ЗДТГ-ын Болзошгүй аваарын зардалын 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг гүйцэтгэж, байгууллагын дарга, нягтлан бодогч, холбогдох албан тушаалтнуудад зөрчил, дүгнэлтийг танилцуулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2025.10.20-ны өдрийн 56/25 дугаартай удирдамжаар Жаргалант сумын Жаргалант ус Дулааны станц ОНӨХК-ийн 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг гүйцэтгэж, байгууллагын дарга, нягтлан бодогч, холбогдох албан тушаалтнуудад зөрчил, дүгнэлтийг танилцуулж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2025.10.20-ны өдрийн 57/25 дугаартай удирдамжаар Жаргалант сумын ЗДТГ-ын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг гүйцэтгэж, байгууллагын дарга, нягтлан бодогч, холбогдох албан тушаалтнуудад зөрчил, дүгнэлтийг танилцуулж ажиллалаа.

Газрын “Нэгдсэн менежментийн тогтолцоо”-ны хэрэгжилтэд стандарт баталгаажуулалтын “МонСертф” ХХК-ийн ОУ-ын тэргүүлэх аудитор Т.Болорчимэг, ОУ-ын тэргүүлэх аудитор О.Хишигмаа нар 2025 оны 11 дүгээр сарын 05-07-ны өдрүүдэд ажиллаж, Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 Олон улсын стандартын магадлах-1 аудит, Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 37001:2016 Олон улсын стандартын магадлах-2 аудит, Эрсдэлийн

менежментийн тогтолцооны ISO 31000:2018 Олон улсын стандартын анхдагч аудитыг тус тус хийж гүйцэтгэлээ.

Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 Олон улсын стандартын магадлах-1 аудит, Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 37001:2016 Олон улсын стандартын магадлах-2 аудит, Эрсдэлийн менежментийн тогтолцооны ISO 31000:2018 Олон улсын стандартын анхдагч аудитаар нийт 164 шалгуур үзүүлэлтээр дүгнүүлж, аудитад амжилттай хамрагдлаа.



2025.11.07-ны өдөр байгууллагын хуваарьт талбайн цас, мөсийг цэвэрлэлээ.



2. Сургалт, зөвлөгөөн

- Улаанбаатар хотод 2025.11.13-2025.11.14- ний өдрүүдэд Сангийн яам, Азийн хөгжлийн банкттай хамтран зохион байгуулж “Улсын салбарын дотоод аудитуудыг чадавхжуулах, олон улсын туршлага солилцох” зөвлөгөөнд Газрын дарга оролцлоо. Мөн 10 албан хаагч цахимаар хамраглаа.



- 2025.11.13-ны өдрийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран “Ногоон амьдралын хэв маяг” сэдэвт дотоод сургалтад 10 албан хаагч хамрагдлаа.



- 2025.11.13-ны өдөр “Эрүүл мэндийн газар”-аас зохион байгуулсан Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд 10 албан хаагч хамрагдсан.



- Улаанбаатар хотод 2025.11.19-ны өдөр зохион байгуулагдсан “Дотоод аудитуудын форум”-д Газрын дарга, Ахлах мэргэжилтэн, Нягтлан бодогч нар хамрагдлаа. Тус форумоор дотоод аудитын чиг хандлага, шилдэг туршлага, инноваци болон AI ашиглалтын кейсүүдийг танилцуулах, харилцан суралцах зэрэг асуудлуудыг хэлэлцжээ.



3. Үүрэг даалгавар

- 2025 оны 11 дүгээр сарын 20-ны Жаргалант сумын “Соёлын төв”-д зохион байгуулагдсан **“Иргэдийн оролцоо, төлөөлөгчийн манлайлал, төрийн үйлчилгээ”** нэгдсэн өдөрлөгт байгууллагын 2 албан хаагч “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах, иргэдэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж ажиллалаа.



- 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр **“Залуучуудын ордон”**-д зохион байгуулагдсан нэгдсэн өдөрлөгт байгууллагын 1 албан хаагч Даваат, Шанд, Рашаант, Их залуу, Баян-овоот, Яргуйт, Малчин, Уртын гол багуудын иргэд, олон нийтэд мэдээлэл түгээж байна.



- 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр “Баянцагаан соёлын төв”-д зохион байгуулагдсан нэгдсэн өдөрлөгт байгууллагын 1 албан хаагч Баянцагаан, Говил багуудын иргэд, олон нийтэд мэдээлэл түгээж байна.



- 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр “Хэмнэл соёлын төв”-д зохион байгуулагдсан нэгдсэн өдөрлөгт байгууллагын 1 албан хаагч Дэнж, Эрдэнэ, Чингэл багуудын иргэд, олон нийтэд мэдээлэл түгээж байна.



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР